

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГСА-2026/02-6/СТА-НА-НТГ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойр хот
2026 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа,
Утас: 70543179
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр, Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179 Цахим хаяг:
darkhanbatb@audit.gov.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер

Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Дарханбат

Аудитор
С.Батцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70543179
дугаарын утсаар
харилцана уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 213 тоот

2026 оны 04 дүгээр сар

А. Орон нутгийн 2025 оны төсвийг тооцоолол, судалгаанд бус өмнөх оны гүйцэтгэлд үндэслэж төлөвлөсөн байна. 11

А.1 Орон нутгийн 2025 оны төсвийг Сангийн яамнаас баталсан удирдамж, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн байна. 11

А.2 Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ биелсэн боловч нэр төрлөөрөө /7 нэр төрлийн орлого/ бүрэн биелээгүй байна. 16

Б.Төсвийн хөрөнгө оруулалтын саналд төлөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй төсөл, арга хэмжээ төлөвлөсөн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй, төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна. 21

Б.1 Төсвийн төлөвлөлтөд шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ төлөвлөсөн, зардлыг нөөц хэлбэрээр үлдээж эх үүсвэрт төлөвлөөгүй, олон нийтэд танилцуулж санал аваагүй байна..... 21

В.ТЭЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ, тоон болон чанарын үнэлгээгээр 88.3 хувьтай хэрэгжсэн байна. 30

Г.Шилэн данс, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх оноос нэмэгдсэн байна.32

Г.1. Өмнөх онтой харьцуулахад Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 14 хувиар, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 81 хувиар тус тус нэмэгдсэн байна. 32

Д. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага 71 хувьтай хэрэгжсэн байна. 33

Д.1 “Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” гүйцэтгэлийн аудитын шийдвэр 75 хувьтай хэрэгжсэн байна. 33

Д.2 Орон нутгийн 2024 оны жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр өгсөн аудитын шийдвэр 67 хувьтай хэрэгжсэн байна..... 33

Дүгнэлт

Зөвлөмж

ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМХТЗ	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл
АМХТЗ	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл
АТБӨЯХ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БТСГ	Биеийн тамирын спортын газар
БХНСАХЗ	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДНС	Засаг даргын нөөц сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЗЗНДНТУТХ	Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨББ	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТАМНАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХХ	Үл хөдлөх хөрөнгө
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦСҮТ	Цөм сүргийн үржлийн төв
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит үндэслэл, бүрэн эрх:

хийх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179 дүгээр тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэсэн.

Аудитын зорилт:

Орон нутгийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Орон нутгийн 2025 оны төсвийн орлогыг холбогдох хууль, журамд заасан шаардлагад нийцүүлэн иж бүрэн, бодиттой тооцож төлөвлөсөн үү?
2. Орон нутгийн 2025 оны төсвийн зардлыг бодиттой тооцож төлөвлөн, зориулалтын дагуу зарцуулсан уу?
3. Орон нутгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ, төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?
4. Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансы хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан уу?
5. Өмнөх аудитын зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

1. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
2. Төсвийн тухай хууль
3. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль,
4. Нийгмийн даатгалын багц хуулиуд
5. Төрийн аудитын тухай хууль
6. Төрийн хэмнэлтийн тухай хууль
7. Татварын багц хуулиуд
8. Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд
9. Бусад холбогдох хууль тогтоомж, журам, заавар

Аудитын хамарсан хүрээ:

Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг, орон нутгийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, ТЕЗ-ийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа мэдээлэл болон бусад баримт материалуудад тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 200, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817- 5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилтын хүрээнд хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашигласан.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, С.Батцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл:

Аудитын гүйцэтгэлийн үе шатыг 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүлээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ИТХ-ын 2025 оны 02, Сүмбэр сумын ИТХ-ын 2025 оны 09, Шивээговь сумын ИТХ-ын 2025 оны 05, Баянтал сумын ИТХ-ын 2025 оны 06 дугаар тогтоолоор Говьсүмбэр аймгийн 2025 оны нийт орлого ба тусламжийн орлого 30,087.1 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 32,508.4 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Төсвийн зарлагын төлөвлөгөөг 39,064.8 сая төгрөгөөр баталж, зарлагын 8,977.7 сая төгрөгийг эхний үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. 2025 оны аймгийн төсвийн зарлагын гүйцэтгэл 31,316.0 сая төгрөг буюу 80 хувьтай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч 22 хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, жилийн эцсийн үнэлгээгээр 88.3 хувьтай хэрэгжсэн гэж үнэлэгджээ.

Дүрслэл товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл №1	УИХ-аас батлагдсан 2025 оны орон нутгийн орлогын төлөвлөгөөнд орсон өөрчлөлт	9
Дүрслэл №2	Татварын бус орлого /нэр төрлөөр/	11
Дүрслэл №3	Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	13
Дүрслэл №4	2025 оны хүү, торгуулийн орлогын, гүйцэтгэлийг эх үүсвэрээр нь өмнөх онтой харьцуулсан судалгаа	17

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №1	2025 оны суурь орлогын саналыг Сангийн яамны хянасан суурь орлоготой харьцуулсан харьцуулалт	8
Хүснэгт №2	Татварын орлогын төлөвлөгөө, ногдуулалтын харьцуулалт	9-10
Хүснэгт №3	ОНХНС-аас шилжүүлсэн орлого, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг анх батлагдсан, төсвийн тодотголын харьцуулалт	11
Хүснэгт №4	ОНХС, ХХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих зардлын харьцуулалт	11
Хүснэгт №5	2024 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлын харьцуулалт	12
Хүснэгт №6	2025 оны орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	12
Хүснэгт №7	2025 оны татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл нэр, төрлөөр	13-14
Хүснэгт №8	Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	14
Хүснэгт №9	2025 оны татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл татварын нэр төрлөөр	14
Хүснэгт №10	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	15
Хүснэгт №11	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	15
Хүснэгт №12	Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр төрөл бүрээр өмнөх онтой харьцуулсан судалгаа	16-17
Хүснэгт №13	Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	17-18
Хүснэгт №14	Аймгийн 2025 оны хөрөнгө оруулалтын саналд тусгасан, төсөл, арга хэмжээ	18
Хүснэгт №15	Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр болон төлөвлөсөн төсөл, арга хэмжээний тоо	19
Хүснэгт №16	Төлөвлөлтийн шаардлага хангаагүй барилга байгууламж, засварын ажлын жагсаалт	20
Хүснэгт №17	Давсан орлого, хэмнэгдсэн зардал	21
Хүснэгт №18	Аймгийн 2024 оны төсвийн зарлага	22
Хүснэгт №19	Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл	22
Хүснэгт №20	Санхүүжилтийн эрх хаагдсаны улмаас шилжих хөрөнгө оруулалтаар батлагдсан ТАХ-ний жагсаалт	23
Хүснэгт №21	Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл	23
Хүснэгт №22	Орон нутгийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл	24
Хүснэгт №23	Хоршоо хөгжүүлэх сангийн гүйцэтгэл	25
Хүснэгт №24	Засаг дарга дансны төлөвлөгөө, гүйцэтгэл	26
Хүснэгт №25	Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт	27-28
Хүснэгт №26	Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт	28
Хүснэгт №27	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт (ТТСД)	30
Хүснэгт №28	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт (НТГ)	30

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	30,087,101.5	32,508,471.5
2	3.1.01.1.1 Татварын орлого	16,730,054.4	19,340,989.84
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	13,320,791.3	15,610,608.22
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	13,190,791.3	15,406,195.92
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	11,780,791.3	14,022,995.04
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	100,000	151,110.83
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	590,000	426,952.97
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	290,000	247,521.63
9	3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	430,000	557,615.45
10	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-500,000	-499,956.98
11	3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-500,000	-499,956.98
12	3.1.01.1.1.1.4 ААН-ын орлогын албан татвар	630,000	704,369.28
13	3.1.01.1.1.1.4.01 ААН-ын орлогын албан татвар	630,000	704,369.28
14	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	938,800	1,058,410.6
15	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	746,000	778,394.89
16	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	6,800	6,131
17	3.1.01.1.1.3.3 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	166,000	165,261.01
18	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	20,000	108,623.7
19	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	2,470,463.1	2,671,971.02
20	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	367,000	458,269.11
21	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	80,000	141,444.61
22	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	37,000	44,095.85
23	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	250,000	272,728.64
24	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	1,399,389.4	1,924,029.69
25	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	526,000	977,872.84
26	3.1.01.1.1.8.2.02 Дуудлага худалдаа	873,389.4	946,156.85
27	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	704,073.7	289,672.22
28	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	54,073.7	83,313.21
29	3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	650,000	206,359.01
30	3.1.01.1.2 Татварын бус орлого	13,357,047.1	13,167,481.66
31	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	2,407,656.7	2,281,158.76
32	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	1,820,000	1,667,644.69
33	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	358,137.5	292,892.72
34	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	39,219.2	44,052.74
35	3.1.01.1.2.1.6 Түрээсийн орлого	190,300	172,895.06
36	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	0.0	103,673.55
37	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	10,949,390.4	10,886,322.9
38	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	5,829,689.5	5,766,622

39	3.1.01.1.2.4.3 Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	5,119,700.9	5,119,700.9
40	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	39,064,828.8	31,315,991.74
41	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	24,386,355.8	21,684,031.63
42	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,051,956.9	20,038,200.49
43	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,635,350.7	8,199,450.71
44	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	3,665,492.9	3,870,553.85
45	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	3,683,971.4	3,235,629.62
46	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	647,088.1	606,078.84
47	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	615,953	465,319.59
48	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	22,845.3	21,868.82
49	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,045,028.3	952,811.71
50	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	691,879	656,340.98
51	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	88,213.6	78,138.58
52	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	62,524.9	44,138.98
53	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	26,438.3	32,733.38
54	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	175,972.5	141,459.77
55	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,212,539.8	4,880,852.98
56	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	526,135.4	490,070.56
57	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	4,044,462.7	3,852,808.89
58	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	641,941.7	537,973.53
59	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	336,461.7	261,396.27
60	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	59,886.9	44,082.25
61	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	159,460	131,492.33
62	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,844.8	29,625.47
63	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,360	1,997
64	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	70,910	54,199.22
65	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	4,857	4,057
66	3.1.01.2.1.1.5.01 Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	207	207
67	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,650	3,850
68	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	559,113.6	487,575.38
69	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	106,186	65,169.1
70	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,800	1,824
71	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	447,127.6	420,582.28
72	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	188,411	165,128.69
73	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	183,405	162,079
74	3.1.01.2.1.1.7.03 Зочин төлөөлөгч хүлээн авах	5,006	3,049.69
75	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,561,769	2,352,059.34
76	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,514,486.7	2,316,496.26
77	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,062	1,062
78	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	17,538	13,893.01

79	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	2,794.2	1,799.11
80	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,136.2	894.98
81	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,530	12,323.6
82	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	9,221.9	5,590.39
83	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	3,508,425.8	2,734,868.41
84	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	3,464,150.8	2,712,507.91
85	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	44,275	22,360.5
86	3.1.01.2.1.3 ТАТААС	25,000	2,200
87	3.1.01.2.1.3.1 Төрийн өмчит байгууллагад олгох татаас	25,000	2,200
88	3.1.01.2.1.3.1.01 Төрийн өмчит байгууллагад олгох татаас	25,000	2,200
89	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,309,398.9	1,643,631.14
90	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,773,747.8	1,382,941.46
91	3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,773,747.8	1,382,941.46
92	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	535,651.1	260,689.68
93	3.1.01.2.1.4.2.02 Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	40,750	14,625
94	3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	150,000	55,816.8
95	3.1.01.2.1.4.2.06 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	135,493.6	69,449.3
96	3.1.01.2.1.4.2.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	70,707.5	59,270.28
97	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	138,700	61,528.3
98	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,470,068.3	9,100,204.61
99	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	13,470,068.3	9,100,204.61
100	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,208,404.7	531,755.5
101	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	1,208,404.7	531,755.5
102	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-8,977,727.3	1,192,479.76
103	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,977,727.3	-1,192,479.76
104	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	8,977,727.3	-1,192,479.76
105	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	9,038,727.79
106	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	10,231,207.56
107	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	474	495
108	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	16	16
109	6.1.01 Төсвийн байгууллага	16	16
110	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	229	262
111	6.2.01 Удирдах ажилтан	44	44
112	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	135	166
113	6.2.03 Үйлчлэх ажилтан	43	46
114	6.2.04 Гэрээт ажилтан	7	5
115	6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	229	216
116	6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	104	91
117	6.5.02 Төрийн тусгай албан хаагч (ТТ)	2	2
118	6.5.06 Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	3	2

119	6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	90	91
120	6.5.10 Гэрээт ажилтан	6	4
121	6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ)	24	25
122	6.5.14 Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	0.0	1

БҮЛЭГ А

Орон нутгийн 2025 оны төсвийг тооцоолол, судалгаанд бус өмнөх оны гүйцэтгэлд үндэслэж төлөвлөсөн байна.

А.1 Орон нутгийн 2025 оны төсвийг Сангийн яамнаас баталсан удирдамж, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн байна.

А.1.1 Орон нутгийн 2025 оны төсвийг Сангийн яамнаас баталсан удирдамжийн дагуу төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3¹-т зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулахаар заасан. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хурлаар хэлэлцэн батлагдсан байна. Орон нутгийн 2025 оны төсвийн орлогын талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатайг дурдсан байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт

- 1.1 Тухайн аймаг, сумын нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, дэмжих, тэдгээрийн тээврийн үйл ажиллагааг саадгүй явуулахад анхаарч ажиллах
- 1.2 Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг татварын удирдлагын нэгдсэн системд бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх, мөн харьяа татварын албатай хамтран татвар төлөгчийн цахим төлбөрийн баримтын бүртгэлд хяналт тавих ажлыг зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

2. Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр

- 2.1 Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг татварын удирдлагын нэгдсэн системд бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх, мөн харьяа татварын албатай хамтран татвар төлөгчийн цахим төлбөрийн баримтын бүртгэлийн хяналт тавих ажлыг зохион байгуулах
- 2.2 Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр сум, дүүргийн Засаг дарга, Усны газар, сав газрын захиргаа, төвлөрсөн ус хангамжийн байгууллага, татварын алба ус ашиглагчийн үйлдвэр, үйлчилгээнд ашигласан усны хэмжээг бодитоор тодорхойлон, төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэхэд хамтран ажиллах
- 2.3 Татварын ерөнхий хуулийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ гүйцэтгэгч татварын албанд татварын өртэй тохиолдолд улсын төсвийн санхүүжилтээс татварын өрөнд суутган тооцох ажлыг үргэлжлүүлэх
- 2.4 Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10-д “аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь”

Аймгийн СТСХ-ээс Сангийн яамнаас баталсан удирдамжийн дагуу орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар хийгдсэн арга хэмжээний талаар ирүүлээгүй байна.

¹ жилийн төсвийн хязгаарт багтаасан байх

А.1.2. Орон нутгийн 2025 оны төсвийн нийт орлогыг Төсвийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн байна.

Аймгийн 2025 оны суурь орлогын саналыг Сангийн яамны хянасан суурь орлоготой харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №1

(сая төгрөгөөр)

Орлогын нэр төрөл	Аймгийн 2025 оны суурь орлогын санал	Сангийн яамны хянасан суурь орлогын дүн	Зөрүү
	1	2	3=2-1
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	11,294.0	10,700.0	
Үйл ажиллагааны орлого	100.0	180.0	80.0
Хөрөнгийн борлуулсны орлого	290.0	290.0	-
Хөрөнгийн орлого	500.0	760.0	260.0
Шууд бус орлого	150.0	150.0	-
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(600.0)	(500.0)	100.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	746.0	746.0	-
Бууны албан татвар	5.0	5.0	-
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	166.0	166.0	-
Улсын тэмдэгтийн хураамж	80.0	80.0	-
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	27.0	27.0	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	210.0	210.0	-
Газрын төлбөр	526.0	526.0	-
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	850.0	850.0	-
Дуудлага худалдаа	300.0	10.0	
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	54.1	54.1	-
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	600.0	754.0	154.0
Нийт татварын орлогын дүн	15,298.1	15,008.1	594.0
Түрээсийн орлого	156.0	56.0	(100.0)
Төсөвт байгууллагын өөрийн орлого	61.0	20.0	(41.0)
Торгуулийн орлого	1,400.0	1,400.0	-
Нийт татварын бус орлогын дүн	1,617.0	1,476.0	(141.0)
Суурь орлогын нийт дүн	16,915.1	16,484.1	453.0

Эх сурвалж: Аймгийн СТСХ-ээс ирүүлсэн 2025 төсвийн баримт бичиг

Хүснэгтээс харахад: Сангийн яам нь аймгаас хүргүүлсэн татварын суурь орлогын саналаас үйл ажиллагааны орлогыг 80.0 сая, хөрөнгийн орлогыг 260.0 сая, хувь хүний орлогын албан татварын буцаан олголтод 100.0 сая, ус рашааны нөөц ашигласны төлбөр 154.0 сая төгрөгөөр болж нэмэгдүүлж, дээрх 4 орлогыг 26-80%-аар буюу 594.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Татварын бус орлогыг аймгаас хүргүүлсэн саналаас 9%-аар буюу 141.0 сая төгрөгөөр бууруулан Сангийн яамнаас хянасан байна.

А.1.3. Татварын орлогыг төлөвлөхдөө бодит, тооцоо судалгаанд бус өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.


1. Нийт орлого ба тусламжийн орлого

Аймгийн ИТХ-ын 2025 оны 02, Сүмбэр сумын ИТХ-ын 2025 оны 09, Шивээговь сумын ИТХ-ын 2025 оны 05, Баянтал сумын ИТХ-ын 2025 оны 06 дугаар тогтоолоор тайлант онд нийт орлого ба тусламжийн орлогод 30,087.1 сая төгрөгийг төвлөрүүлэхээр батлагдсан байна. Үүнд:

1.1 Татварын орлого

УИХ-аас батлагдсан 2025 оны орон нутгийн орлогын төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №1 / сая төгрөгөөр/



2025 онд УИХ-аас анх батлагдсан 15,008.1 сая төгрөгийн татварын орлогыг аймаг, сумдын ИТХ-аар 1,742.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 16,750.1 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан байна.

Татварын орлогын төлөвлөгөөнд 7 нэр, төрлийн орлогыг 2,316.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Нэмэгдүүлэн баталсан орлогыг нэр төрлөөр нь харуулбал:

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого-1,080.8 сая
- Шууд бус орлого-300.5 сая
- Бууны албан татвар-1.8 сая
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр-10.0 сая
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж-40.0 сая
- Дуудлага худалдаа-863.4 сая
- Малын тоо толгойн албан татвар-20.0 сая

Аймгийн СТСХ-ээс орлого нэмэгдүүлж төлөвлөсөн тооцоо судалгаа, шалтгаан тайлбарыг ирүүлээгүй байна.

Хүснэгт №2 Татварын орлогын төлөвлөгөө, ногдуулалтын харьцуулалт (сая төгрөгөөр)

Татварын нэр төрөл	Төлөвлөгөөний дүн	Татварын ногдуулсан дүн	Зөрүү	Тайлбар
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого	11,780.8	14,023.0	(2,242.2)	Шивээ овоо ХК-наас 2023-2024 оны барагдаагүй өр төлбөр болон 2025 оны төлөгдөөгүй өр төлбөрийг төлсөн.
Үйл ажиллагааны орлого	100.0	151.1	(51.1)	Хялбаршуулсан горим ашиглан 1 хувиар татвар төлөх боломжтой болсон
Хөрөнгө борлуулсны орлого	290.0	247.5	42.5	Шинэ байр ашиглалтад орсноор иргэн хоорондын байрны борлуулалт буурсан
Хөрөнгийн орлого	590.0	427.0	163.0	
Шууд бус орлого	450.0	557.6	(107.6)	Эрдэнэс таван толгой ногдол ашиг хуваарилсны дагуу ногдол ашгаас суутгасан
Хувь хүний орлогын албан татварын буцаалт	(500.0)	(500.0)	-	
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	746.0	778.4	(32.4)	Шивээ овоо ХК 2023 оны үл хөдлөх хөрөнгийн өр төлбөр барагдуулсан

Бууны албан татвар	6.8	6.1	0.7	
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	166.0	165.3	0.7	
Улсын тэмдэгтийн хураамж	80.0	141.4	(61.4)	"Шивээ овоо" ХК нь улсын тэмдэгтийн хураамж төлсөн
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	37.0	44.1	(7.1)	Орон сууц баригдсантай холбоотой элс хайрга авах зөвшөөрөл олгогдсон "Хар Шороо эх бүрдэн" ХХК болон иргэн Г.Балдандорж, "Баян нексус" ХХК нар түгээмэл тархацтай ашигт малтмал албан татварыг төлсөн
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	250.0	272.7	(22.7)	Өмнөх оны төлөгдөөгүй өр төлбөрөөс төлөгдсөн
Газрын төлбөр	526.0	977.9	(451.9)	"Шивээ овоо" ХК 2022-2023 оны газрын төлбөрийн өр төлбөрийг барагдуулсан
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	630.0	704.4	(74.4)	Өмнөх оны ААНОАТ-ын өр төлбөртэй татвар төлөгч өр төлбөрөө бүрэн барагдуулсан.
Дуудлага худалдаа	873.4	946.2	(72.8)	Төлөвлөлт дутуу хийгдсэн
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	54.1	83.3	(29.2)	Баянтал суманд шонхор агнах зөвшөөрөл олгосон
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	650.0	206.4	443.6	"Шивээ овоо" ХК-ны ус рашааны нөөц ашигласны төлбөр төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй
Малын тоо толгойд ногдуулах албан татвар	20.0	108.6	(88.6)	Өмнөх оны дутуу төлөгдсөн албан татварыг төлүүлсэн
Татварын орлогын дүн	16,750.1	19,341.0	(2,590.9)	

Эх сурвалж: Аймгийн СТСХ, Татварын газраас ирүүлсэн судалгаа

Хүснэгтээс харахад цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн татвар болон хог хаягдлын үйлчилгээний хураамж, газрын төлбөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогын ногдуулалт нийтдээ 2,749.2 сая төгрөгөөр давж биелсэн нь өмнөх онуудын өр төлбөр төлөгдсөнөөс шалтгаалсан байна.

1.2 Татварын бус орлого

Татварын бус орлогын төлөвлөгөөнд 4 нэр, төрлийн орлогыг 850.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Дүрслэл №2 Татварын бус орлого /нэр төрлөөр/

Түрээсийн орлого -190.3	• Түрээсийн орлогыг 134.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн
Төсөвт байгууллагын өөрийн орлого - 61.0 сая	• Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг Усан спорт сургалтын төв, авто замын сан, СДОА тус бүр 20.0 сая, АЗДТГ-ын өөрийн орлого 1.0 сая нийт 61.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн
Хүү, торгуулийн орлого-1,800.0 сая	• Хүү, торгуулийн орлогыг орлогын нэр төрөл бүрээр төлөвлөөгүй, 2024, 2025 оны хагас жилийн гүйцэтгэлд үндэслэн 400.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн
Сумдын ХХС орлого-275.4 сая	

- Сумдын ХХС-ийн орлогыг 275.4 сая төгрөгөөр төлөвлөсөн

1.3 Улсын болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг

Хүснэгт №3 ОНХНС-аас шилжүүлсэн орлого, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг анх батлагдсан, төсвийн тодотголын харьцуулалт / сая төгрөгөөр/

Орлогын төрөл	Анх батлагдсан	Тодотгол батлагдсан	Зөрүү	Хувь
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	8,374.2	5,829.7	2,544.5	30%
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	9,282.0	5,119.7	4,162.3	45%
Нийт дүн	17,656.2	10,949.4	6,706.8	75%

Эх сурвалж: 2025 оны ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгтээс харахад: Төсвийн тодотголоор ОНХНС-аас шилжүүлсэн орлого УИХ-аас анх баталсан орлогоос 30% буюу 2,544.5 сая төгрөгөөр бууруулж 5,829.7 сая, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 45 хувь буюу 4,162.3 сая төгрөгөөр бууруулж 5,119.7 сая төгрөгөөр тус тус батлагдсан байна.

А.1.4. Шивээговь сум давсан орлого, хэмнэгдсэн зардал болох 324.0 сая төгрөгийг эх үүсвэрт батлаагүй.

ОНХС, ХХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих зардлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4 (сая төгрөгөөр)

Д/д	Аймаг, сумдын нэр	2024 оны ОНХС, ХХС-ийн дансны үлдэгдэл	Эхний үлдэгдлээс санхүүжихээр баталсан	Зөрүү
1	Аймаг	717.3	717.3	0.0
2	Сүмбэр	838.5	838.5	0.0
3	Шивээговь	284.6	284.6	0.0
4	Баянтал	153.1	153.1	0.0
	Нийт дүн	1,993.5	1,993.5	0.0

Хүснэгтээс харахад: ОНХС, ХХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих зардлыг бүрэн баталсан байна.

2024 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлыг аймаг, сумдаар нь хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5 (сая төгрөгөөр)

Д/д	Аймаг, сумдын нэр	2024 оны		2024 оны нийт давсан орлого, хэмнэгдсэн зардал	Баталсан 2024 оны тэнцлийн ашиг	Зөрүү
		Давсан орлого	Хэмнэгдсэн зардал			
1	Аймаг	1,955.8	2,528.5	4,484.3	4,484.3	-
2	Сүмбэр сум	1,704.3	308.7	2,013.0	2,013.0	-
3	Баянтал сум	133.5	90.4	223.9	223.9	-
4	Шивээговь сум	250.0	74.0	324.0	-	324.0
	Нийт	4,043.6	3,001.6	7,045.2	6,721.2	324.0

Хүснэгтээс харахад: 2024 онд нийт 7,045.2 сая төгрөгийн давсан орлого, хэмнэгдсэн зардалтай тайлагнагдсан байна. Нийт давсан орлого, хэмнэгдсэн зардлын 63.6%-ийг аймаг, 28.6%-ийг Сүмбэр сум, 3.2%-ийг Баянтал сум, 4.6%-ийг Шивээговь сум тус тус эзэлж байна.

Шивээговь сум орлогыг төлөвлөхдөө давсан орлого хэмнэгдсэн зардлаас санхүүжих 324.0 сая төгрөгийг дутуу тооцож баталсан байна. Иймд Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2²-т зааснаар төсвийг иж бүрэн, үнэн зөв тооцоолж батлуулах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

A.2 Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ биелсэн боловч нэр төрлөөрөө /7 нэр төрлийн орлого/ бүрэн биелээгүй байна.

A.2.1 Аймгийн ИТХ-аас баталсан татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 15%-аар давж биелсэн боловч 5 нэр төрлийн татварын орлого 650.5 сая, 2 нэр төрлийн татварын бус орлого 149.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Нийт орлого ба тусламжийн орлого:

2025 онд нийт орлого ба тусламжийн орлого 30,087.1 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 32,508.5 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд: татварын орлого 19,341.0 сая, татварын бус орлого 2,281.2 сая, ОНХНС-аас шилжүүлсэн орлого 5,766.6 сая, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 5,119.7 сая төгрөг байна.


1. Татварын орлого:

2025 оны орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Он	Татварын орлого /сая төгрөгөөр/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
2025	16,750.1	19,341.0	(2,590.9)	115%
2024	12,607.6	15,288.9	(2,681.4)	121.3%

Дүрслэл №3

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /2 жилээр/



Дүрслэлээс харахад: Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 33%-аар нэмэгдүүлэн төлөвлөсөн ба өмнөх оны гүйцэтгэлээс 26.5%-аар өссөн байна. 2024 онд орлогын төлөвлөгөө 21.3%-аар давж биелсэн бол тайлант онд төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл 15%-аар давж биелсэн байна.

2025 оны татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр, төрлөөр нь харуулбал:

Хүснэгт №7		(сая төгрөгөөр)			
№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь

² төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх

1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого	11,780.8	14,023.0	(2,242.2)	119%
2	Үйл ажиллагааны орлого	100.0	151.1	(51.1)	151%
3	Хөрөнгө борлуулсны орлого	290.0	247.5	42.5	85%
4	Хөрөнгийн орлого	590.0	427.0	163.0	72%
5	Шууд бус орлого	450.0	557.6	(107.6)	130%
6	Хувь хүний орлогын албан татварын буцаалт	(500.0)	(500.0)	-	100%
7	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	746.0	778.4	(32.4)	104%
8	Бууны албан татвар	6.8	6.1	0.7	90%
9	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	166.0	165.3	0.7	100%
10	Улсын тэмдэгтийн хураамж	80.0	141.4	(61.4)	177%
11	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	37.0	44.1	(7.1)	119%
12	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	250.0	272.7	(22.7)	109%
13	Газрын төлбөр	526.0	977.9	(451.9)	186%
14	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	630.0	704.4	(74.4)	112%
15	Дуудлага худалдаа	873.4	946.2	(72.8)	108%
16	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	54.1	83.3	(29.2)	154%
17	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	650.0	206.4	443.6	32%
18	Малын тоо толгойд ногдуулах албан татвар	20.0	108.6	(88.6)	543%
	Татварын орлогын дүн	16,750.1	19,341.0	(2,590.9)	115%

Эх сурвалж: 2025 оны ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгтээс харахад: татварын орлогын төлөвлөгөөний биелэлт нийт дүнгээрээ 2,590.9 сая төгрөгөөр давж биелсэн байна. Тухайлбал: 12 нэр, төрлийн орлого нийт 3,261.4 сая төгрөгөөр давж биелсэн бол 5 орлогын төлөвлөгөө нийт 650.5 сая төгрөгөөр тасарсан байна.

2 Татварын бус орлого:

2025 онд Сангийн яамнаас орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө 1,476.0 сая төгрөгөөр хянагдаж ирсэн бөгөөд аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 850.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2,326.7 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Он	Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл			/сая төгрөгөөр/
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
2024	1,888.8	2,845.5	150.7%	
2025	2,326.7	2,281.2	98%	

Хүснэгтээс харахад: 2025 онд татварын бус орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 23.2% буюу 437.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бөгөөд гүйцэтгэлээр тайлант оны орлогын төлөвлөгөөг 2%-аар буюу 45.5 сая төгрөгөөр тасарсан байна.

2025 оны татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг татварын нэр төрлөөр нь гаргасан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №9

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Татварын бус орлого		2,326.7	2,281.2	45.5
2.1.	Хүү, торгуулийн орлого	1,800.0	1,667.6	132.4
2.2.	Түрээсийн орлого	190.3	172.9	17.4
2.3.	Төсөвт байгууллагын өөрийн орлого	61.0	85.8	(24.8)
2.4.	Сумдын ХХС орлого	275.4	251.2	24.2
2.5	Бусад орлого	-	103.7	(103.7)

Хүснэгтээс харахад: Бусад орлогод 103.7 сая төгрөгийг бүртгэсэн нь төсвийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд бус ерөнхий дансанд төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, түрээсийн орлогын нийт 42.6 сая төгрөгийг барагдуулаагүй, төсөвт бүрэн төвлөрүүлээгүй. /2 ААНБ 41.9 сая, 1 иргэн/ Иймд Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1³ дэх заалтыг зөрчсөн, гэрээний үүргээ биелүүлээгүй, төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлээгүй 2ААНБ-аас түрээсийн тоног төхөөрөмжийг буцаан татаж авах, гэрээг цуцлах ажлыг хууль журамд нийцүүлэн зохион байгуулах, өмнөх оны түрээсийн төлбөрийн үлдэгдлийг бүрэн төлүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3 Улсын болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №10 (сая төгрөгөөр)

Он	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2024	6,836.4	6,836.4	-
2025	5,119.7	5,119.7	-

Тус аймаг нь 2024 онд улсын төсвөөс 6,836.4 сая, тайлант онд улсын төсвөөс 5,119.7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан ба өмнөх онтой харьцуулахад 25%-аар буурсан байна.

2025 онд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэгт дотоодын газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 70 хувь, АМНАТ-ийн хуваарилалт 10 хувь, АМХТЗ-ийн 50 хувь, АМАТЗ-ийн 50 хувь нийт 5,829.7 сая төгрөгөөр батлагдсан байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №11 (сая төгрөгөөр)

Он	ОНХНС-ийн санхүүжилт			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
2025	5,829.7	5,766.6	63.1	99%
2024	7,000.3	6,740.7	259.7	96.3

Хүснэгтээс харахад: 2025 онд ОНХНС-аас олгох санхүүжилт өмнөх оноос 16.7%-иар бууруулж батлагдсан ба гүйцэтгэлээр санхүүжилтийг 1% буюу 63.1 сая төгрөгөөр дутуу авсан байна.

³ хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх

А.2.2 Орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний хүрээнд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого, газрын төлбөрийн албан татварын өмнөх онд үүссэн 626.6 сая төгрөгийн өр төлбөр барагдсан байна.

Татварын орлогын төлөвлөгөөг 3,241.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн шалтгааныг тодруулахад:

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогын төлөвлөгөө давсан нь “Шивээ-овоо” ХК 1,903.9 сая төгрөгийн 2023-2024 оны барагдаагүй өр төлбөр болон 2025 оны төлөгдөөгүй өр төлбөрийг “Өрийн ажиллагаа” явуулан данс битүүмжлэх ажил хийгдсэнээр бүрэн төлүүлсэн.
- Үйл ажиллагааны орлого давсан нь хувиараа бизнес эрхлэгч болон малчид татварын хялбаршуулсан горим ашиглан 1 хувиар татвар төлөх боломжтой болсон тул 2025 онд хувь хүний орлогын албан татварын тайлан гаргах иргэд нэмэгдэн татвараа төлсөн.
- Шууд бус орлого давсан нь “Эрдэнэс таван толгой” ХК-наас ногдол ашиг хуваарилсны дагуу ногдол ашгаас суутгасан албан татвар 2025 оны 02 сар болон 05 сард 317.3 сая төгрөг суутгагдан төсөвт төвлөрүүлсэн
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар давсан нь “Шивээ-овоо” ХК 2023 оны үл хөдлөх хөрөнгийн өр төлбөрийг барагдуулсан
- Улсын тэмдэгтийн хураамж давсан нь "Шивээ овоо" ХК нь улсын тэмдэгтийн хураамж төлсөн
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр давсан нь шинээр орон сууц баригдсантай холбоотой элс хайрга авах зөвшөөрөл олгогдсон. Мөн "Хар Шороо эх бүрдэн" ХХК болон иргэн Г.Балдандорж, "Баян нексус" ХХК нар түгээмэл тархацтай ашигт малтмал албан татварыг төлсөн
- Хог хаягдлын хураамж давсан нь өмнөх оны төлөгдөөгүй өр төлбөрөөс барагдсан
- Газрын төлбөр давсан нь "Шивээ овоо" ХК 2022-2023 оны газрын төлбөрийн өр төлбөр төлөгдөөгүй байсан “Өрийн ажиллагаа”-ны дагуу данс битүүмжлэх ажил хийгдсэнээр 327.3 сая төгрөг төлүүлсэн. "Эйкүсора" ХХК-ны газрын төлбөрийн 2024 оны 77.1 сая төгрөгийг өр төлбөрөөс барагдуулсан
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар давсан нь ААНОАТ-ын өмнөх оны өр төлбөртэй татвар төлөгчид өр төлбөрөө бүрэн барагдуулсан.
- Дуудлага худалдааны орлого давсан нь тодорхой төлөвлөх боломжгүй бөгөөд тайлант хугацаанд хэрэгжүүлсэн арга хэмжээтэй холбоотой.
- Ан амьтны нөөц ашигласны төлбөр давсан нь Баянтал суманд шонхор агнах зөвшөөрөл олгож 22.2 сая төгрөгийн агнуурын төлбөр төлөгдсөн.
- Малд ногдуулах албан татвар давсан нь өмнөх оны өр төлбөрийг барагдуулан ажилсантай холбоотой

Татварын 5 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 650.5 сая төгрөгөөр тасарсан шалтгаан, хэрэгжилтийг хангуулах талаар ямар ажил хийгдсэн талаар аймгийн Татварын газраас тодруулбал:

- Хөрөнгө борлуулсны орлого 32.4 сая төгрөгөөр тасарсан нь Илчит сансар болон ОСО констракшн нь захиалгын гэрээгээр шинэ орон сууц ашиглалтад оруулж борлуулсантай холбоотойгоор иргэд хоорондын үл хөдлөх хөрөнгийн борлуулалт буурсан.
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөр тасарсан нь Шивээ овоо ХК төлөвлөсөн хэмжээнээс бага ус ашигласан
- Бууны албан татвар тасарсан нь галт зэвсэг ашиглагчдын бүртгэл шинэчлэл хийгээгүйтэй холбоотой
- Хөрөнгийн орлого тасарсан нь иргэдийн хадгаламж буурсантай холбоотой
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар тасарсан нь төлөвлөлт буруу хийгдсэнээс шалтгаалсан байна.

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр төрөл бүрээр өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №12


(сая төгрөгөөр)

№	Орлогын нэр төрөл	2024 он		2025 он		Зөрүү	
		Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	8,249.4	10,102.7	11,780.8	14,023.0	3,531.4	3,920.3
2	ХХОАТ-ын буцаан олголт	(400.0)	(398.0)	(500.0)	(500.0)	(100.0)	(102.0)
3	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	820.0	661.7	746.0	778.4	(74.0)	116.7
4	АТБӨЯХ-ийн албан татвар	150.0	170.2	166.0	165.3	16.0	(4.9)
5	Улсын тэмдэгтийн хураамж	101.8	132.3	80.0	141.4	(21.8)	9.1
6	Газрын төлбөр	520.0	313.0	526.0	977.9	6.0	664.9
7	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	450.0	342.9	650.0	206.4	200.0	(136.5)
8	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	40.0	177.7	54.1	83.3	14.1	(94.4)
9	Дуудлага худалдааны орлого	300.0	864.5	873.4	946.2	573.4	81.7
10	Хөрөнгийн орлого	305.0	378.2	590.0	427.0	285.0	48.8
11	Хөрөнгө борлуулсны орлого	185.0	299.5	290.0	247.5	105.0	(52.0)
12	Шууд бус орлого	733.4	962.8	450.0	557.6	(283.4)	(405.2)
13	Үйл ажиллагааны орлого	130.0	210.9	100.0	151.1	(30.0)	(59.8)
14	Бууны албан татвар	5.0	5.7	6.8	6.1	1.8	0.4
15	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	65.0	63.1	37.0	44.1	(28.0)	(19.0)
16	Хог хаягдлын хураамж	190.0	228.2	250.0	272.7	60.0	44.5
17	Малын тоо толгойд ногдуулах албан татвар	163.1	93.5	20.0	108.6	(143.1)	15.1
18	ААН-ийн орлогын албан татвар	600.0	680.0	630.0	704.4	30.0	24.4
Татварын орлогын нийт дүн		12,607.7	15,288.9	16,750.1	19,341.0	4,142.4	4,052.1

Эх сурвалж: 2024, 2025 оны ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгтээс харахад: Татварын орлого нийт дүнгээрээ өмнөх онтой харьцуулахад 4,142.4 сая төгрөгөөр илүү төлөвлөгдсөн ба гүйцэтгэл 4,052.1 сая төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: өмнөх оноос татварын 12 нэр төрлийн орлогыг 1.8-573.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 6 нэр төрлийн орлогыг 21.8-283.4 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 10 нэр төрлийн орлого 0.4-3,920.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 8 нэр төрлийн орлого 4.9-405.2 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

2025 оны хүү, торгуулийн орлогын, гүйцэтгэлийг эх үүсвэрээр нь өмнөх онтой харьцуулсан судалгааг дүрслэлээр харуулбал:



Дүрслэл №4

Дүрслэлээс харахад: Өмнөх онтой харьцуулахад улсын байцаагчийн хяналт шалгалтаар тавьсан төлбөрийн орлого, татварын хяналт, торгуулийн орлого, бусад нэр заагдаагүй орлого 49.7-804.3 сая төгрөгөөр тус тус буурсан, төсөвт газрын өөрийн орлого 78.0 сая, ЦХ-ийн хүү торгуулийн орлого 97.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Хүү торгуулийн орлогыг нэр төрлөөр нь төлөвлөх боломжгүй байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №13

(сая төгрөгөөр)

№	Байгууллага	2024 он		2025 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлого					
1	Аймгийн Засаг даргын тамгын газар	0.7	1.3	1.0	1.1
2	Усан спорт сургалтын төв	20.0	27.4	20.0	25.8
3	Цөм сүрэг үржлийн төв ОНӨҮГ	20.0	4.3	-	1.8
4	Авто замын сан	20.0	28.5	20.0	27.3
5	Сум дундын ойн анги	20.0	28.7	20.0	29.8
6	Нийтийн тээврийн үйлчилгээ	5.0	-	-	-
Дүн		85.7	90.2	61.0	85.8
Сумдын сангийн орлого					
1	Сумдын Хоршоо хөгжүүлэх сан	386.9	236.8	275.4	251.2
Дүн		386.9	236.8	275.4	251.2
НИЙТ ДҮН		472.6	327.0	336.4	337.0

Эх сурвалж: 2024, 2025 оны ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгтээс харахад: 2025 оны өөрийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 28.8% буюу 136.2 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн байна. Энэ нь Сумдын хоршоо хөгжүүлэх сангуудын орлогыг тухайн жилийн зээлийн эргэн төлөлтөд уялдуулж төлөвлөсөнтэй холбоотой буурсан, Цөм сүргийн үржлийн төвийн орлогыг 20.0 сая, нийтийн тээврийн үйлчилгээний орлогыг 5.0 сая төгрөгөөр бууруулсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө нийт 0.6 сая төгрөг буюу 1.8%-аар давсан байна. Үүнд төсөвт байгууллагын өөрийн орлого 24.8 сая төгрөгөөр давсан боловч Сумдын ХХС-ийн орлого 24.2 сая төгрөгөөр тасарсан байна.

БҮЛЭГ Б

Төсвийн хөрөнгө оруулалтын саналд төлөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй төсөл, арга хэмжээ төлөвлөсөн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй, төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Б.1 Төсвийн төлөвлөлтөд шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ төлөвлөсөн, зардлыг нөөц хэлбэрээр үлдээж эх үүсвэрт төлөвлөөгүй, олон нийтэд танилцуулж санал аваагүй байна.

Б.1.1 Төсвийн зардлыг Сангийн яамнаас ирүүлсэн тухайн жилийн төсвийн удирдамжийн дагуу боловсруулж баталсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг 2024 оны 11 сарын 08-ны өдөр Улсын Их хурлаар хэлэлцэу баталсан. Сангийн сайдаас Говьсүмбэр аймгийн Засаг даргад Төсвийн төсөл боловсруулах удирдамжийг хүргүүлсэн бөгөөд аймгийн Санхүү, төрийн сангийн

хэлтсээс орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулж Төрийн аудитын байгууллагад хүргүүлэн дүгнэлт гаргуулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулсан байна.

Б.1.2 Төсвийн хөрөнгө оруулалтын саналд төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байна.

Говьсүмбэр аймгийн 2025 оны орон нутгийн төсөвт ОНТХО, ОНХС, Авто замын сан, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэх нийт 15,125.2 сая төгрөгийн 122 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан, төсөл, арга хэмжээ

Хүснэгт №14

(сая.төгрөгөөр)

№	Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ	ОНХС	ОНТХО	Авто замын сан	БХНСАХ	Нийт
1	Хөрөнгө оруулалт	5,017.9	3,075.4	624.0	118.0	8,835.3
2	Их засвар	740.0	1,498.0			2,238.0
3	Тоног төхөөрөмж	255.0	876.7			1,131.7
4	Зураг төсөв	60.0	283.0	10.0		353.0
5	Хөтөлбөр, төсөл арга хэмжээ	394.8		407.3	55.3	857.4
6	Шилжих хөрөнгө оруулалт	1,121.9	530.7	57.2		1,709.8
	Дүн	7,589.6	6,263.8	1,098.5	173.3	15,125.2
	Шинэ	50	25	6	11	92
	Шилжих	20	8	2		30
	Нийт	70	33	8	11	122

(Эх сурвалж: (Аймаг, сумын ИТХ-ын тогтоол)

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт:

2024.11.10-ны өдөр батлагдсан Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгийг 8,374.2 сая төгрөгөөр баталсан бөгөөд төсвийн орлого бүрдэлттэй холбоотойгоор төсөвт тодотгол хийж, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгийг 5,829.7 сая төгрөг болгон бууруулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр болон төлөвлөсөн төсөл, арга хэмжээний тоо

Хүснэгт №15

(сая төгрөгөөр)

Аймаг, сумын нэр	ОНХНС-гаас	Төсвөөс санхүүжих	Урьд оны үлдэгдлээс	Нийт эх үүсвэр	Төлөвлөсөн ТАХ-ний тоо	
					Шинэ	Шилжих
Аймгийн ОНХС	1,271.7		717.3	1,989.0	2	15
Сүмбэр сумын ОНХС	2,381.3	166.7	423.4	2,971.4	19	3
Баянтал сумын ОНХС	365.2	52.3	34.0	451.5	19	0
Шивээговь сумын ОНХ	1,811.5	180.3	185.7	2177.5	10	2
Нийт	5,829.7	399.3	1,360.4	7,589.4	50	20

(Эх сурвалж: АЗДТГ-аас ирүүлсэн судалгаа, хөрөнгө оруулалтын баримт)

Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь холбогдох эрх зүйн акттай нийцэж буй эсэхийг шалгахад зураг төсөв нь магадлалаар баталгаажуулаагүй 1,800.0 сая төгрөгийн гадна дулааны шугам, цахилгаан хангамжийн ажлыг төлөвлөсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3⁴, 4.1.7⁵, 4.1.9⁶, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁷, Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.5⁸, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.3, Сангийн сайдын 2021 оны 86-р тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.3⁹-т заасныг зөрчиж байна.

Төсвийн төсөлд санал дүгнэлт өгөх аудитаар уг төслийн төлөвлөлтийг хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах санал, дүгнэлтийг хүргүүлсэн боловч төслийн бэлэн байдал хангагдаагүй худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд буюу 05 сарын-31-ний дотор бүрэн дуусгах гэж заасныг зөрчсөн тул хэрэгжээгүй, төсөвт буцаан татагджээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт:

Аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн төсөлд орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 25, шилжих 4 нийт 29 төсөл, арга хэмжээг 5,791.9 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Аймгийн ИТХ-ын 2024.12.24-ний өдрийн ээлжит бус 4 дүгээр хуралдааны 05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар 2025 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 21, шилжих 7 нийт 28 төсөл, арга хэмжээг 5,136.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Уг төсвийг аймгийн ИТХ-ын 2025.07.22-ны өдрийн ээлжит 8 дугаар хуралдааны 02 дугаар хавсралтаар шинээр хэрэгжих 25, шилжих 8 нийт 33 төсөл, арга хэмжээг 6,263.8 сая төгрөг болгон тодотгож баталсан байна.

Төлөвлөлтийн шаардлага хангаагүй барилга байгууламж, засварын ажлын жагсаалт

Хүснэгт №16

(сая төгрөгөөр)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Тайлбар
1	Өгөөж захын уулзвараас 2 дугаар сургуулийн уулзвар хүртэлх авто замын ажил	1,000.0	2024 онд 20.0 сая төгрөгөөр зураг төсөв боловсруулах төсөв нь батлагдсан боловч эцсийн байдлаар хүлээн аваагүй.
2	Халдвартын эмнэлгийн их засварын ажил	550.0	2021 онд ММ Архитектур ХХК-иар 14.8 сая төгрөгөөр хийгдсэн зураг төсөвтэй боловч ашиглаагүй.
3	Усан спорт сургалтын төвийн засварын ажил	400.0	2024 онд засварын ажлын зураг төсөвт 20.0 сая төгрөг баталсан боловч эцсийн байдлаар хүлээн аваагүй.

⁴ 4.1.3.үр ашигтай байх;

⁵ 4.1.7.бодитой байх;

⁶ 4.1.9.хариуцлагатай байх;

⁷ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁸ 25.2.5.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

⁹ 4.3.3 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;

4	Хуучин хүүхдийн эмнэлгийг оффиссын зориулалтаар засварлах ажил	480.0	582.3 сая төгрөгийн төсөвтэй боловч зураггүй. Мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй.
5	Шинээр баригдах орон сууцны хорооллын цахилгаан хангамжийн ажил (1-р байршил)	300.0	Магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй.
Нийт		2,730.0	

(Эх сурвалж: АЗДТГ-аас ирүүлсэн судалгаа, хөрөнгө оруулалтын баримт)

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4, Барилгын тухай хуулийн 25.2.5, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолын 3.2.2.2-т заасны дагуу сүүлийн 2 жилийн хугацаанд магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй байх шаардлагад нийцээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг төсөв батлагдах хугацаанд магадлалын дүгнэлтээр баталгаажуулаагүй, тоног төхөрөмжийн хувьд төсөв захирагчдаас ирсэн саналыг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлээгүй нь дээрх зөрчил гарах шалтгаан болж байна.

Цаашид хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлтийг хууль тогтоомжид нийцүүлэх, үр дүнтэй төлөвлөх зайлшгүй шаардлага үүссэн байна.

Авто замын сангийн төлөвлөлт:

Аймгийн ИТХ-ын 2024.12.24-ний өдрийн ээлжит бус 4 дүгээр хуралдааны 05 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралтаар шинээр хэрэгжих 5, шилжих 2 төсөл арга хэмжээнд 1,098.5 сая төгрөгийн зардлыг баталсан байна. Төсвийн тодотголоор мөнгөн дүнд өөрчлөлт ороогүй боловч хэрэгжих төсөлд өөрчлөлт оруулжээ.

Авто замын сангийн хөрөнгийг Авто замын сангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3¹⁰, 24.4¹¹, 24.5¹², Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 3.5¹³, 3.5.1¹⁴, 3.5.2¹⁵-т заасны дагуу зам засвар арчлалтын зардалд батлагдсан төсвийн 90 хувийг, хяналт шалгалт, технологийн шинэчлэлтэд 10 хувийг төлөвлөж, зарцуулах зориулалтаар зарцуулах хууль эрх зүйн зохицуулалттай байна.

Авто замын сангийн 2025 оны төсвөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний төсөл арга хэмжээний 22 хувь нь буюу 241.3 сая төгрөгийн “Найрамдал хотхоны 1,15 дугаар байрны дундах зогсоолын ажил” нь дээрх хууль, журмын шаардлагад нийцээгүй байна.

Б.1.3 Төсвийн зардлын хэмнэлтийг бодитоор тооцож төсвийн төсөлд тусгаагүй, нөөц хэлбэрээр төсөвт үлдээсэн байна.

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд давсан орлого, хэмнэгдсэн зардлын хэмжээг 960.6 сая, давсан орлогыг 2,244.7 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 1,955.8 сая төгрөгийн давсан орлого, 2,528.5 сая төгрөгийн хэмнэгдсэн зардалтай байна.

Хүснэгт №17

Давсан орлого, хэмнэгдсэн зардал

(сая төгрөгөөр)

¹⁰ 24.3. Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ.

¹¹ 24.4. Авто замын сангийн хөрөнгөөр авто замын арчлалт, урсгал засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ.

¹² 24.5. Авто замын сангаас авто замын засвар, арчлалтын ажлыг хариуцсан байгууллагын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, техник технологийг шинэчлэх, хөндлөнгийн хяналт тавих, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, авто замын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлнэ.

¹³ 3.5. Авто замын сангийн тухайн жилийн төсвийг төлөвлөх, хуваарилахад дараахь зарчмыг баримтална:

¹⁴ 3.5.1. төсвийн 90-ээс багагүй хувийг Авто замын тухай хуулийн 24.3, 24.4-т тус тус заасан үйл ажиллагаанд;

¹⁵ 3.5.2. төсвийн 10 хүртэлх хувийг Авто замын тухай хуулийн 24.5-д заасан үйл ажиллагаанд.

Бусад эх үүсвэр	Төсвийн төсөл	2024 оны нийт давсан орлого, хэмнэгдсэн зардал /2025.07.28 №02/	Зөрүү
Давсан орлого	2,244.7	1,955.8	288.9
Хэмнэгдсэн зардал	960.6	2,528.5	(1,567.9)
Нийт	3,207.3	4,484.3	(1,279.0)

(Эх сурвалж: Орон нутгийн төсвийн 2025 оны төсвийн төсөлд санал дүгнэлт өгөх аудитын тайлан, аудитаар хийсэн тулгалт, ажлын баримт)

Хүснэгтээс харахад: Давсан орлого, хэмнэгдсэн зардлыг бодитой тооцоогүйгээс төсвийн төслийн санал, АИТХ-аар баталсан тогтоолоос 1,279.0 сая төгрөгөөр дутуу байна.

Энэ нь хүлээгдэж буй орлого, зардлын гүйцэтгэлийг үндэслэл муутай, бодит тооцоо судалгаанд тулгуурлан хийдэггүйгээс шалтгаалж байгаа бөгөөд оновчтой тооцож чадаагүйгээс 2025 оны төсөвт батлагдаагүй зардлын нөөц үүсэж, төсвийн тодотгол хүртэл эдийн засгийн эргэлтэд орох боломжгүй болж, төсвийн хөрөнгийн үр нөлөөтэй зарцуулалтад сөрөг нөлөө үзүүлж байна.

Б.1.4 Төсвийн төсөл боловсруулах явцдаа иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч тусгаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2¹⁶, 67 дугаар зүйлийн 67.3¹⁷-т заасны дагуу төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, иргэдээс гарсан санал хүсэлтийг тухайн шатны ИТХ-д танилцуулах хуулийн зохицуулалттай бөгөөд шат, шатны Засаг дарга нар дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Б.2 Төсвийн төсөлд хүлээгдэж буй гүйцэтгэлийг бодитой тооцож чадаагүйгээс зардлыг нөөц хэлбэрээр үлдээж, санхүүжилтийн эх үүсвэрт тусгаагүй, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй, хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Б.2.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байгаагаас төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хооронд нь гүйлгэж зарцуулсан байна.

2025 оны орон нутгийн төсвийн зарлага төлөвлөлтийн талаар:

УИХ-аас батлагдаж ирсэн 36,583.8 сая төгрөгийн төсвийн зарлагыг ТЕЗ-аас 4,901.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зарлагыг 41,485.1 сая төгрөгөөр батлуулахаар төсвийн төслийг ирүүлснийг аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор 41,847.0 сая төгрөгөөр баталсан.

Аймгийн ИТХ-ын 2025.07.28-ны өдрийн 02, Сүмбэр сумын ИТХ-ын 2025.07.30-ны өдрийн 09, Баянтал сумын 2025.08.06-ны өдрийн 06, Шивээговь сумын ИТХ-ын 2025.08.12-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор 39,064.8 сая төгрөг болгон бууруулжээ.

Хүснэгт №18	“Аймгийн 2025 оны төсвийн зарлагын төлөвлөгөө” (сая.төгрөгөөр)				
Төсвийн зарлагын нэр	УИХ-аас хянасан төсөв	2025 оны төсвийн төсөл	Анх баталсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү
Орон нутгийн суурь зардал	28,209.5	26,684.7	26,733.8	25,211.5	(1,522.3)
ОНХС-гийн зардал	8,374.3	9,008.5	9,977.0	7,589.5	(2,387.5)
ОНХО-ын зардал		5,791.9	5,136.2	6,263.8	1,127.6

¹⁶ 6.5.2.төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;

¹⁷ 67.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

Нийт дүн 36,583.8 41,485.1 41,847.0 39,064.8 (2,782.2)

(Эх сурвалж: Аймгийн Засаг даргын өргөн барьсан төсөв, Сангийн яамнаас ирүүлсэн суурь зардлын төлөвлөгөө, аймаг, сумын ИТХ-ын тогтоол)

Хүснэгтээс харахад: Төсвийн ерөнхийлөн захирагчийн анх батлагдсан төсвийг тодотголоор 2,782.2 сая төгрөгөөр бууруулсан байна. ОНХС болон суурь зардлын хэмжээг 3,909.8 сая төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг 1,127.6 сая төгрөгөөр нэмж баталжээ. Энэ нь татварын орлого тасарч хасах тодотгол хийсэнтэй холбоотой байна. Өмнөх онд нийт төсвийн 78 хувийг хөрөнгө оруулалтын зардалд зарцуулж байсан бол тайлант онд 41 хувь буюу 16,050.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

Хүснэгт №19 Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл: (сая төгрөгөөр)

Төсөл, арга хэмжээ	АОНХС		Сүмбэр		Шивээговь		Баянтал		Нийт		Гүйцэтгэл хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Шилжих хөрөнгө оруулалт	715.8	384.7	270.9	258.2	97.4	93.3			1,084.1	736.1	67.9%
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	1,273.3	717.7	1,794.6	1,383.9	1,950.0	1,472.9	37.8	14.8	5,055.6	3,589.3	71.0%
Их засвар			565.0	415.5			175.0	128.4	740.0	543.9	73.5%
Тоног төхөөрөмж			80.0	77.6			175.0	159.5	255.0	237.1	93.0%
Хөтөлбөр, төсөл, арга хэмжээ			260.8	168.2	70.1	35.0	63.8	20.5	394.8	223.6	56.7%
Зураг төсөв					60.0	23.2			60.0	23.2	38.6%
Нийт	1,989.1	1,102.4	2,971.3	2,303.4	2,177.5	1,624.3	451.6	323.2	7,589.5	5,353.3	70.5%

(Эх сурвалж: ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл 2025)

Аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 70 хувьтай байна.

Санхүүжилтийн эрх хаагдсаны улмаас шилжих хөрөнгө оруулалтаар батлагдсан ТАХ-ний жагсаалт

Хүснэгт №20 (сая төгрөгөөр)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Аймгийн ОНХС	Сүмбэр сумын ОНХС	Шивээговь сумын ОНХС
1	Сүмбэр суманд нийтийн эзэмшлийн талбай, тохижилтын ажил /Гомбосүрэн ноёны талбай/	168.8		
2	Өлзийт суурьшлын бүсийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх ажил		121.2	
3	Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-ын барилгын ажил 1-р үе		258.6	
4	Гэр хорооллын гадна цэвэр ус, гадна бохир усны шугамд холбох ажил			1,418.9
	Дүн	168.8	379.8	1418.9
	Нийт		1,967.5	

(Эх сурвалж: Аудитын ажлын баримт)

Санхүүжилтийн эрх хаагдсаны улмаас шилжих хөрөнгө оруулалтаар 2026 оны төсөвт 1,967.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ батлагджээ.

Аймаг сумын ИТХ-аар хэрэгжүүлэхээр баталсан 70 төсөл, арга хэмжээнээс 47 буюу 67 хувь нь төлөвлөсөн хугацаандаа хэрэгжсэн байна.

Хүснэгт №21 Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл: (сая төгрөгөөр)

ОНХС	Төлөвлөсөн ТАХ-ний тоо	Хүлээн авсан ТАХ-ний тоо	Зөрүү	Гүйцэтгэл хувиар
Аймгийн ОНХС	17	9	8	53%
Сүмбэр сумын ОНХС	22	19	3	86%
Шивээговь сумын ОНХС	12	9	3	75%
Баянтал сумын ОНХС	19	10	9	53%
Нийт	70	47	23	67%

(Эх сурвалж: ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл 2025)

Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний тоо болон гүйцэтгэлийг хавсралт №1-ээс үзнэ үү.

АИТХ-ын 2025.12.04-ний өдрийн ээлжит бус 10 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан аймгийн ОНХС-ийн шилжих хөрөнгийн дүнг 998.6 сая төгрөгөөр баталсан боловч бодит шилжих хөрөнгө оруулалтын хэмжээ 888.6 сая төгрөг байна. Иймд илүү баталсан 110.1 сая төгрөгийг 2026 оны төсвийн тодотголоор залруулах шаардлагатай байна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар аймаг, сумын ОНХС-тай холбоотой 1,552.9 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 1.6 сая төгрөгийн 2 зөвлөмж, 441.0 сая төгрөгийн 2 албан шаардлага өгсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл:

Аймгийн ИТХ-ын 2024.12.24-ний өдрийн 05 дугаар тогтоолоор 5,136.2 сая, 2025.07.28-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 6,263.8 сая төгрөгийн 35 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №22 (сая төгрөгөөр)

Төсөл, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төлөвлөсөн ТАХ	Хүлээн авсан ТАХ	Гүйцэтгэл хувь
Шилжих хөрөнгө оруулалт	530.7	369.7	161.0	70%	8	5	63%
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	3,075.4	1,921.7	1,153.7	62%	10	5	50%
Их засвар	1,498.0	1,182.5	315.5	79%	4	4	100%
Тоног төхөөрөмж	876.7	617.9	239.6	70%	6	4	67%
Зураг төсөв	283.0	21.1	261.9	7%	7	5	71%
Нийт	6,263.8	4,112.9	2,131.7	66%	35	23	66%

(Эх сурвалж: Аудитын ажлын баримт, судалгаа)

Хүснэгтээс харахад: Хөрөнгө оруулалтын төсвийн гүйцэтгэл 66, нийт 35 төсөл, арга хэмжээнээс 23-ыг нь хүлээн авч төлөвлөгөөний хэрэгжилт мөн 66 хувьтай байна.

2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан боловч худалдан авах ажиллагаа амжилтгүй болж огт хэрэгжээгүй дараах төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

1. Шинээр баригдах орон сууцны хорооллын цахилгаан хангамжийн ажил (1-р байршил)-300.0

2. Монгол гэрийн халаалтын багц худалдан авах-37.0 сая
3. Шинээр баригдах амины болон нийтийн орон сууцны барилгын дэд бүтцийн /инженерийн болон цахилгаан хангамж/ ажлын зураг, төсөв-55.0 сая

Аймгийн ИТХ-ын 2025.12.04-ний өдрийн 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад 2025 онд бүрэн хэрэгжээгүй 1,968.1 сая төгрөгийн 30 төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан байна. Аудитаар шилжих хөрөнгө оруулалтаар баталсан хөрөнгийн жагсаалтыг тулгаж үзэхэд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. АИТХ-ын 2025.07.28-ны өдрийн 02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан аймгийн ОНТХО-ын шилжих хөрөнгийн жагсаалтад 2024 онд гүйцэтгэн хүлээн авсан “Барилга байгууламж паспортжуулах”-15.0 сая төгрөгийн ажлыг шилжих хөрөнгө оруулалтаар 2025 онд дахин хийж гүйцэтгэхээр баталсан, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг хянаж батлуулаагүй
2. 2026 оны төсөв батлагдахаас өмнө хүлээн авсан “Төрийн байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах” ажлын хэмнэлт 102.6 сая, аймгийн ОНХС-гийн эх үүсвэртэй давхардуулан шилжих хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн “Гомбосүрэн ноёны цэцэрлэгт хүрээлэнгийн авто зогсоолын засвар шинэчлэлтийн ажил” 176.8 сая нийт 2 төсөл, арга хэмжээний хэмнэлт 279.4 сая төгрөгийг 2026 оны эх үүсвэрт шилжих хөрөнгөөр батлуулж, эх үүсвэрийг буруу батлуулсан.Энэ нь төлөвлөлтөд сөргөөр нөлөөлж байна.
3. “Сүмбэр сумын Найрамдал хотхонд шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгаан хангамжийн ажил”-ын үлдэгдэл санхүүжилт 56.7 сая төгрөг боловч шилжих ажилд 122.6 сая төгрөгөөр тусгасан, санхүүжилтийн мөнгөн дүнг зөрүүтэй батлуулсан.
4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас хийх 899.6 сая төгрөгийн гүйлгээг хөгжлийн сангийн санхүүжилтээс андуурч хийсэн бөгөөд алдааг залруулахдаа 828.0 сая төгрөгөөр хийж, 71.6 сая төгрөгийн зардлыг Орон нутгийн хөгжлийн сангийн зардлаар илүү тайлагнасан.
5. УСДУ ОНӨААТҮГ-т дугуйт экскаватор худалдан авах ажлын барьцаа хөрөнгө 17.4 сая, алданги 1.7 сая төгрөгийг холбогдох дансуудад шилжүүлээгүй, ерөнхий орлогын дансанд тус тус төвлөрүүлж, баталгаат хугацаа дуусахад олгох мөнгөн хөрөнгийг барьцаа дансанд байршуулаагүй

Аймгийн ИТХ-аас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онд шилжих ажлын жагсаалтыг тогтоолын хавсралтаар үнэн зөв баталдаггүй, төсвийг төлөвлөх, санхүүжүүлэх, тайлагнах үе шатанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, албан хаагчдын мэдлэг, туршлага хангалтгүй байгаа нь дээрх зөрчил гарахад нөлөөлсөн байна.

Иймд эх үүсвэр давхардуулан төлөвлөсөн 176.8 сая, ажлын хэмнэлтийн 102.6 сая нийт 279.4 төгрөгийг эх үүсвэрт төлөвлөх, ОНХС-гаас данс андуурч шилжүүлсэн 71.6 сая төгрөгийг залруулах, ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн 19.1 төгрөгийн барьцаа болон алдангийн орлогыг холбогдох дансанд шилжүүлэх, шилжих хөрөнгө оруулалтын жагсаалтыг бэлтгэн аймгийн ИТХ-ын тогтоолын хавсралтаар батлуулах, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг өгөхөөр шийдвэрлэв.

Хоршоо хөгжүүлэх сан

Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрт 908.3 сая төгрөгийг төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр сангийн үйл ажиллагааны зардалд 2.8 сая төгрөгийг сангийн үйл ажиллагааны зардалд зарцуулж 229.0 сая төгрөгийн зээл олгосон байна.

Хүснэгт №23

Хоршоо хөгжүүлэх сангийн гүйцэтгэл

(сая төгрөгөөр)

№	Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Сүмбэр	600.0	1.3	598.7	0.3%

Б.2.2 Төсвийн зарцуулалт, үр дүнг олон нийтэд ил тод танилцуулаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1¹⁸, 6.5.2¹⁹, 6.5.3²⁰, 6.5.4²¹, 6.5.5²², 6.5.6²³, -т тус тус заасны дагуу төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах хуулийн зохицуулалттай байна.

Иргэд олон нийтийн зүгээс төсвийг төлөвлөх шатанд зөвхөн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд санал өгч байгаа бөгөөд бусад эх үүсвэрээс хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хэрхэн авсан, иргэдийн оролцоог хангасан талаарх мэдээллийг бэлтгэж ирүүлээгүй байна. Иймд төсвийн зарцуулалт, үр дүнг иргэд олон нийтэд ил тод мэдээлэх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Б.2.3 Нэмэлт төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 35.7 сая, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 82.6 сая, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 32.6 сая, эхний үлдэгдэл 84.5 сая, нийт 235.4 сая төгрөгийг хүлээн авсан байна.

Үүнээс: Цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 41.8 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 5.3 сая, хангамж, гэрэл цахилгааны зардалд 0.7 сая, хангамж, бараа материалын зардалд 9.7 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 1.2 сая, томилолтын зардалд 0.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 27.9 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 115.9 сая нийт сая төгрөгийг зарцуулж 32.1 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалттай холбоотой алдаа, зөрчил илрээгүй боловч тус дансны харилцахын үлдэгдлээр тайлагнах мөнгөн хөрөнгийг ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ В

ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ, тоон болон чанарын үнэлгээгээр 88.3 хувьтай хэрэгжсэн байна.

В.1 Хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнг зохих хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

¹⁸ 6.5.1.төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх

¹⁹ төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах,

²⁰ 6.5.3.төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах

²¹ 6.5.4.төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах

²² 6.5.5.хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх

²³ 6.5.6.төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаанд дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр мэдээлж байх.

В.1.1 Төсвийн Ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилтот түвшнийг тодорхойлж, Төсвийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2025.07.28 оны 02 дугаар тогтоолоор ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийн дагуу 22 хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг 88.3 хувьтай тайлагнасан байна.

Хүснэгт 25 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт (сая төгрөгөөр)

№	Хөтөлбөрийн код	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн гүйцэтгэл
1	70105	2,224.3	1,996.3	89.8%	116.8%
2	70106	12,603.3	11,247.0	89.2%	103.5%
3	71502	274.6	259.0	94.3%	162.6%
4	70426	262.5	207.6	79.1%	106.7%
5	70418	268.5	225.1	83.8%	93.2%
6	70417	357.3	351.6	98.4%	87.7%
7	71411	541.4	507.2	71.0%	98.9%
		173.3	143.5		97.6%
8	71403	457.1	432.6	94.6%	21.0%
9	71902	40.8	14.6	35.9%	-40.0%
10	71701	667.8	595.3	89.1%	238.0%
11	71602	1,268.4	1,227.6	96.8%	100.0%
12	71702	301.2	232.0	77.0%	100.0%
13	71806	5.0	5.0	100.0%	100.0%
14	71804	765.0	714.8	93.4%	100.0%
15	71802	1,690.1	1,603.6	94.9%	100.0%
16	71801	671.4	648.6	96.6%	100.0%
17	70801	35.8	35.8	100.0%	125.2%
		111.9	85.9	76.8%	105.3%
18	72208	135.0	135.0	100.0%	139.9%
19	71101	1,098.5	756.9	68.9%	66.0%
		300.0	300.0	100.0%	100.0%
20	72101	908.4	231.8	25.5%	100.0%
21	72203	50.0	45.3	90.6%	160.0%
22	70503	13,853.3	9,313.8	67.2%	88.9%
Нийт		39,064.8	31,316.0	80.2%	88.3%

(Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Хүснэгтээс харахад: Төлөвлөсөн хөтөлбөрүүдийн төсвийн гүйцэтгэл 80.1 хувь, хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын үзүүлэлт 88.3 хувьтай хэрэгжсэн гэж аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс үнэлсэн байна. Тайлант хугацаанд 70801 хөтөлбөрт батлагдсан ЦСҮТ-ийг татан буулгах шийдвэр гарсан бөгөөд тус хөтөлбөрт 35.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

В.1.2 Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн тайлагнасан байна.

Төсвийн Ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайланг чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийн дагуу 22 хөтөлбөрөөр тайлагнасан байна.

Хүснэгт №26 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт (сая төгрөгөөр)

№	Хөтөлбөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Төсвийн гүйцэтгэлийн %
1	70105	ОН-ийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	2,224.3	1,996.3	228.0	89.7%

2	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	12,603.3	11,247.0	1,356.4	89.2%
3	71502	Хот байгуулалт, тохижилт	274.6	259.0	15.6	94.3%
4	70426	Төрийн өмчийг хэрэгжүүлэх	262.5	207.6	54.9	79.1%
5	70418	Худалдан авах ажиллагаа	268.5	225.1	43.4	83.8%
6	70417	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	357.3	351.6	5.6	98.4%
7	71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	714.7	650.7	64.0	91.0%
8	71403	Ойжуулах	457.1	432.6	24.5	94.6%
9	71902	Нийгмийн халамж	40.8	14.6	26.1	35.9%
10	71701	Биеийн тамир, спорт	667.8	595.3	72.5	89.1%
11	71602	Эрүүл мэнд	1,268.4	1,227.6	40.8	96.8%
12	71702	Соёл урлаг	301.2	232.0	69.2	77.0%
13	71806	Насан туршийн боловсрол	5.0	5.0	-	100.0%
14	71804	Мэргэжлийн боловсрол	765.0	714.8	50.2	93.4%
15	71802	Ерөнхий боловсрол	1,690.1	1,603.6	86.4	94.9%
16	71801	Сургуулийн өмнөх боловсрол	671.4	648.6	22.7	96.6%
17	70801	Мал аж ахуй хөгжүүлэх	147.7	121.7	26.0	82.4%
18	72208	Ахмад настны хөгжил, хамгаалал	135.0	135.0	-	100.0%
19	71101	Автозам	1,098.5	756.9	341.6	68.9%
20	72101	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	1,208.4	531.8	676.6	44.0%
21	72203	Хүүхдийн хөгжил, хамгаалал	50.0	45.3	4.7	90.6%
22	70503	Орон нутгийн хөрөнгө оруулалт	13,853.3	9,313.8	4,539.5	67.2%
Нийт			39,064.8	31,316.0	7,748.9	80.16%

(Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

БҮЛЭГ Г

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил буураагүй бол Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх оноос буурсан байна.

Г.1. Өмнөх онтой харьцуулахад Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 14 хувиар нэмэгдэж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 37.6 хувиар буурсан байна.

Г.1.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил буураагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар харьяа 15 байгууллагад Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,448.3 сая төгрөгийн зөрчил илэрч, 1,282.2 сая төгрөгийн 12 зөрчилд албан шаардлага, 35.1 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж, 131.0 сая төгрөгийн 2 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага тус тус өгсөн байна. Өмнөх онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,250.5 сая төгрөгийн зөрчил илэрч байсан бөгөөд тайлант онд 197.8 сая төгрөгөөр нэмэгдэж зөрчлийн дүн буураагүй байна.

Г.1.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил буурсан байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан гүйцэтгэж, 5 байгууллагаас 23.8 сая төгрөгийн 7 зөрчил илэрч 20.4 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 1.3 сая төгрөгийн 1 зөвлөмж, 2.1 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тус тус тогтоосон байна. Үүнд:

- **Баянтал сумын ЗДТГ, ОНХС:** Өмнөх аудитаар насжилт өндөр байгаа авлагыг барагдуулах зөвлөмжийг өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй тул 13.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, тэмцээн уралдаан, шагнал урамшуулал зарцуулсан 1.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- **Илчлэг шивээ, Төхижилт Сүмбэр ОНӨААТҮГ:** Суудлын автомашинд шатахуун хэрэглэсэн боловч зарцуулалтад тавих хяналтгүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан зөрчилд 7.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн.
- **Шивээговь сумын ЗДТГ:** Хог тээврийн автомашинд төлөвлөсөн зардлаас хэтрүүлж зарцуулсан 1.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, аймаг сумын хооронд тогтоосон маршрут, явсан км-ээс хэтрүүлж зарцуулсан шатахууны 0.8 сая төгрөгийн зөрчилд тус тус төлбөрийн акт тогтоосон.

Өмнөх оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 38.2 сая төгрөгийн 8 зөрчил илэрч байсан бол 2025 онд 23.8 сая төгрөгийн 7 зөрчил илэрч зөрчлийн дүн 14.4 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж төсвийн сахилга батыг сайжруулах, арвилан хэмнэлттэй байх зарчмыг баримталж ажиллах шаардлагатай байна.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн сэдэвт нийцлийн аудитаар 404.3 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 18.8 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 345.3 сая төгрөгийн 11 албан шаардлага, 40.2 сая төгрөгийн 5 зөвлөмжийг өгч хэрэгжилтийг тооцсон бөгөөд Үндэсний аудитын газарт 10 санал уламжилсан байна.

БҮЛЭГ Д Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага 71 хувьтай хэрэгжсэн байна.

Д.1 “Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” гүйцэтгэлийн аудитын шийдвэр 75 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт №27 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт (ТТСД)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	0.0	3	0	75%
Нийт дүн	3	0.0	3	0	75%

Зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд аймгийн Засаг даргын 2025.09.29-ний А/946, 2025.12.24-ний А/1310, 2025.12.19-ний 88 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн бөгөөд 75 хувьтай хэрэгжсэн байна.

Д.2 Орон нутгийн 2024 оны жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр өгсөн аудитын шийдвэр 67 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт №28 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт (НТГ)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	326.3	2	294.8	67%
Зөвлөмж	3	178.2	2	178.2	67%
Нийт дүн	6	504.5	4	504.5	67%

Өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилт 67 хувьтай байна. Тухайлбал: 31.4 сая төгрөгийн түрээсийн орлогыг барагдуулаагүй зөрчилд албан шаардлага өгсөн боловч тайлант онд түрээсийн авлагыг барагдуулаагүй байна.

Иймд гэрээний хэрэгжилтийг дүгнэж, шаардлагатай тохиолдолд гэрээг цуцлах, тоног төхөөрөмжийг буцаан авах албан шаардлага хүргүүлсэн. Мөн төсвийн төслийг олон нийтэд танилцуулан санал авах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй гэж үнэлэгдсэн байна.

Аудитаар нийт **817.7** сая төгрөгийн зөрчил илэрч, **324.0** сая төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж, **493.7** сая төгрөгийн 6 зөрчилд 2 албан шаардлага өгсөн.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- Орон нутгийн 2025 оны төсвийг Сангийн яамнаас баталсан удирдамжийн дагуу төлөвлөсөн байна.
- Орон нутгийн 2025 оны төсвийн нийт орлогыг Төсвийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн байна.
- Татварын орлогыг төлөвлөхдөө бодит, тооцоо судлагаанд бус өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.
- Шивээговь сум давсан орлого, хэмнэгдсэн зардал болох 324.0 сая төгрөгийг эх үүсвэрт батлаагүй байна.
- Аймгийн ИТХ-аас баталсан татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 15%-иар давж биелсэн боловч 5 нэр төрлийн татварын орлого 650.5 сая, 2 нэр төрлийн татварын бус орлого 149.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.
- Орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний хүрээнд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого, газрын төлбөрийн албан татварын өмнөх онд үүссэн 626.6 сая төгрөгийн өр төлбөр барагдсан байна.
- Төсвийн зардлыг Сангийн яамнаас ирүүлсэн тухайн жилийн төсвийн удирдамжийн дагуу боловсруулж баталсан байна.
- Төсвийн хөрөнгө оруулалтын саналд төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байна.
- Төсвийн зардлын хэмнэлтийг бодитоор тооцож төсвийн төсөлд тусгаагүй, нөөц хэлбэрээр төсөвт үлдээсэн байна.
- Төсвийн төсөл боловсруулах явцдаа иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч тусгаагүй байна.
- Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байгаагаас төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хооронд нь гүйлгэж зарцуулсан байна.
- Төсвийн гүйцэтгэл зарцуулалт, үр дүнг олон нийтэд ил тод танилцуулаагүй байна.
- Нэмэлт төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
- Төсвийн Ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилтот түвшнийг тодорхойлж, Төсвийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн байна.
- Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн тайлагнасан байна.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил буураагүй байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил буурсан байна. “Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” гүйцэтгэлийн аудитын шийдвэр 75 хувьтай хэрэгжсэн байна.
- Орон нутгийн 2024 оны жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр өгсөн аудитын шийдвэр 67 хувьтай хэрэгжсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймаг, сумдын Засаг дарга нарт:

- Төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг олон нийтэд танилцуулж, иргэдээс гарсан санал хүсэлтийг тухайн шатны ИТХ-д танилцуулах арга хэмжээ авах

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст:

- Сумдын төсвийн тогтоолд эх үүсвэрийг бүрэн тусгасан эсэхийг хянах, шилжих хөрөнгө оруулалтын жагсаалтыг төсөв баталсан тогтоолын хавсралтаар батлуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд буюу тайланг гардаж авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ
УЛАМЖЛАХ САНАЛ**



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар A/12

Чойр

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9, 18.10 дахь заалт, 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, "Эрх шилжүүлэх тухай" 2025 оны А/175 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газарт болон аймгийн ИТХ-ын дарга (Ш.Билэггүмбэрэл), аймгийн Засаг дарга (Т.Бат-эрдэнэ) нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацааны дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Т.Бат-эрдэнэ)-д зөвлөсүгэй.
4. Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор, аудиторуудад үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Г.Наранбаяр)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА